



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/85

Хэрлэн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5 дахь заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4-т заасныг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг хэсэгчлэн шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өргөдлийн дагуу "Уртбулаг" ХХК-ий эзэмшлийн Хэрлэн сумын 1 дүгээр баг, "Амирлан оршихуй" ХХК-ий баруун талд байрлах, худалдаа, үйлчилгээний зориулалттай 1296 м² газрыг иргэн Цэдэндоржийн Дуламсүрэнд шилжүүлэн эзэмшүүлсүгэй.
2. Иргэн Ц.Дуламсүрэнгийн эзэмшил газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай.
3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүрэг болгосугай.
4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг иргэн Ц.Дуламсүрэнд даалгасугай.
5. Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2004 оны 129 дүгээр захирамжийн хавсралтын 3 дахь хэсгийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

- 01 452